

**«ПРАМАНАСАМУЧЧАЯ-
PRAMANASAMUSSAYA»-ГИЙН
ТӨВД ТАЙЛБАРТ ХИЙСЭН
ДАНДАР АГРАМБЫН
АРИУТГАЛ+**

Р. БЯМБАА

Энэтхэг оронд хөгжсөн буддын учир шалтгааны ухааныг үндэслэгч бол VI зууны үед амьдарч байсан Энэтхэгийн гүн ухаантан Дигнага юм. Тэрээр буддын учир шалтгааны ухааны эхийг үндэслэн

— «Праманасамуччая (Prainūnasamussaya-Tsad na kum la btus pa Бүхнээс түүсэн шалгадаг»¹

— «Аламбанепарикша (Alambanapiksa-Dimigs pa brtags pa-оногдохууныг шинжлэхүй»²

— «Трикалапарикша (Trikalapariksa-Dus gsun rtag pa Гурван цагийн шинжлэл»³

— «Ньяяпарабэса (Nyayapavesa-Tsad ma'i bstan bcos rigs pa la jugs pa Шалгадагийн шасдир ухаанд с рох»⁴

— «Хэтуцакрадамару (Hteticaksadamaru-Gtan tsigs kyi khor Хотлохуйн хүрд» гэх зэрэг нилээд олон бүтээлийг туурвисан байна. Эдгээр бүтээлээс хамгийн алдартай, учир шалтгааны ухааны гол бүтээл нь Праманасамуччая "Prainūnasamussaya" юм.

Энэ зохиол нь: 1. Илт онохуй (mngon sum gyi le'u)

2. Өөрийн тусын (rang don rjes dpag gi le'u)

3. Бусдын тусын (gzhan don rjes dpag gi le'u)

4. Жинхэнэ ба гоомой үлгэрийн (dpe dang dpe ltar snang gi le' u)

5. Бусдыг хааж шинжилсэн (gzhan sel brtags pa'i le'u)

6. Эргэж ороогдохыг шинжилсэн (1tag gshod brtags pa'i le'u) гэсэн зургаан бүлэгтэй, шүлэглэсэн байдлаар бичигдсэн бөгөөд уг зохиолд юмс үзэгдлийн шинж чанар, шалтгаант холбоо, тусгай ба ерөнхийн шинж чанар тэргүүтэйг илэрхийлж, тэдгээрийг учир шалтгааны ухааны нотолгоо ба няцаалт, үгүйсгэлийн гаргалгаа, харшилахуйн нотолгоо тэргүүтний үүднээс тус тус тайлбарласан байна.

Зохиогч өөрөө уг зохиолдоо тайлбар⁶ бичсэн байхаас гадна Энэтхэгийн гүн ухаантан нарын бичсэн тайлбарууд, Данжуурын «Шалгадаг ухааны аймагт»⁷ байна. Төвдийн эрдэмтдээс анх гүн ухаантан Жалцав Дармаринчин (1364—1432) Днгнадагийн өмнө дурдсан зохиолд тайлбар хийж,

+ Хэвлэлийн явцад гарсан болон зохиогчийн гаргасан алдааг засаж залруулах үйл ажиллагааг төвд хэлэнд «Шүүдэг—zhus dag, шүүж ариутгах; Жон-салва — skyon gsal ba, гэмийг тодруулах; Даг- Эл---dag dnyed, ариутгах» гэх мэт олон янзаар нэрлэдэг бөгөөд хуучин монгол хэлэнд «Ариутгал» хийх гэдэг.

1. Дэргэ барын Данжуур (УННС) 1983 дугаар боть, 1-р тал

2. Мөн тэнд, 86-р тал

3. Мөн тэнд, 87-р тал

4. Мөн тэнд, 89-р тал

5. Мөн тэнд, 93-р тал.

6. Дэргэ барын Данжуур 183 дугаар боть. 14-р тал

7. Мөн тэнд, Шалгадаг ухааны аймагт (183—193-р ботид бүй тайлбаруудыг дурьдаж болох юм.

түүнийгээ «Шалгадаг судрын тийн номлол»⁸ гэж нэрлэжээ. Энэ тайлбар нь Төвдийн Дашлхүнбо (bkra shis ihun po), Гүн бум (sku 'bum), Монголын Их Хүрээ гэсэн гурван газар хэвлэгдсэн байна. Уг номын Их Хүрээний бар нь Гүнбум бараас хуулбарласан тул энэ хоёр барын ном нь хоорондоо адил юм.

Жалцав Дармаринчингийн тайлбарыг Төвд газар ингэж удаа дараалан хэвлэхэд алдаа мадгийн зүйл нилээд гарсан бололтой байна.

Ийнхүү хэвлэлийн явцад гаргасан алдаа мадгийг XIX зууны үеийн Монголын гүн ухаантан, Халхын Түшээт хан аймгийн Дайчин вангийн хошууны Шадавдандар (Bshad-grub-bstan-dar, 1835-1915) буюу Дандар аграмба (Bstan-dar sngag-ram-pa) ариутган шүүсэн байна.

Дандар аграмба нь дундад зууны үеийн Монголын шашны хэл болох төвд хэлээр зохиол бүтээлээ туурвиж байсан бөгөөд түүний зохиолын эмхтгэл гурван боть болдог билээ. Тэдгээр бүтээлээс хамгийн алдартай нь Төвд Ганжуурын хэвлэлд хийсэн ариутгал юм. Дандар аграмба Ган жуурын 108 ботиос 70 боть буюу Доман (Сударын аймаг)⁹, Ширчин (Билэг чинадын аймаг)¹⁰, Палчин (Олонхийн аймаг)¹¹, Гонзэг (Чухал давхархалын аймаг)¹², Дүлва (Винайн аймаг)¹³ гэсэн таван бүлгийн алдаа мадгийг шүүн зассан байна.

Ганжуурын төвд хэвлэлд хийсэн Дандар аграмбын энэ шүүдгийн тухай Академич Ц. Дамдинсүрэн «Ганжуурын төвд хэвлэлүүдэд хийсэн Дандар аграмбын ариутгал (шүүдэг)¹⁴ гэдэг өгүүлэлд тодорхой өгүүлсэн байна.

Харин энд өгүүлэн буй Жалцав Дармаринчингийн бичсэн «Праман самуччая»-гийн тайлбарын төвд хэвлэлийн явцад гарсан алдаа мадгийг Дандар аграмба засаж ариутгасан тухай урьд өмнө аман ба сурвалж бичгийн мэдээ байгаагүй, судалгаанд өртөөгүйгээр үл барам уг ариутгал нь зохиогчийн бүрэн зохиолын эмхтгэлд орж барлагдаагүй гар бичмэлээр уламжлагдан ирсэн байна.

Иймд бидэнд олдоод байгаа уг ариутгалыг товч танилцуулвал:

Дандар аграмба ариутгалаа: Tsad na mdo'i dar tika bkra shis lhun po dang sku 'bum rag ma gnyis kyi yig skyon 'dogs byed nor bu Ke-te-ka «Шалгадаг судрын Дармаринчингийн тайлбар, Дашлхүнбо, Гүнбум хоёр барын үсгийн гэм сэжгийг таслагч зэндмэний Гэдага»¹⁵ гэж нэрлэжээ.

Цаасны хэмжээ: 45,5 x 9 см

Эх бичгийн хэмжээ: 38 x7 см

Хуудасны тоо: 16

Уг бичмэл ном нь зохиогчийн өөрийн анх бичсэн эх биш, харин хожим хуулсан хуулбар бололтой бөгөөд орос цагаан цаасан дээр хар бэхээр бичсэн, бичгийн хэв тогтуун гаргац сайтай, алдаа мадаггүй, мөн элдэв зураг чимэг байхгүй болно.

8. «Tsad ma mdo'i rnam bshad» сүнбумын «Nga» буюу дөрөв дүгээр боть, (УННС-гийн төвд хөмрөгт) 133 хуудас.

9. “Ga” буюу 3-р боть, mdo mang gi zhus dag, 52 хуудас.

10. sher phyin gyi zhus dag, 15 хуудас.

11. phal chen gyi zhus dag, 13 хуудас.

12. dkon brtzegs kyi zhus dag, 16 хуудас.

13. dul ba'i zhus dag, 18 хуудас (УННС-гийн төвд хөмрөгт).

14. Монголын судлал. - Том IX (17). Fasc. 2. УБ. 1982. 35-45-р тал

15. Гэдага нь санскрит үг бөгөөд булингартсан усыг тунгаагч чадалтай эрдэний нэр юм. Зохиогч «Праманасамуччая 3-гийн төвд тайлбар дахь алдааг энэ номоороо ариутгаж байгаа болохоор үг номоо энэ эрдэнэтэй зүйр, ан адилтгаж ийм нэр өгсөн болно.

Энэхүү ариутгалыг хэн зохиосныг нотлох баримт төгсгөлийнхөө үгэнд байгаа тул энд сийрүүлбэл: "tsad ma mdo yi dar tika par gnyis kyil/yig skyon 'dogs byed nor bu Ke-ta-ka//byed po sa mtha'i rigs smra zlos gar mkhan/ming btags gryis kyis ming zur spras pa yi //Bshad-grub-bstan dar zhes bya'i ming can no// «Шалгадаг судрын тайлбар, хоёр барын¹⁶ үсгийн гэм сэжгийг таслагч зэндмэний Гэдагаг үйлдэгч нь (бичсэн), өгүүлээчийн дуриагч, нэрийн өнцгийг хоёр цолоор чимсэн¹⁷ Шадав дандар¹⁸ хэмээх болой» гэсэн байна. Иш татсан зүйлээс үзвэл Дарма ринчингийн бичсэн «Праманасамуччая»-гийн Их тайлбарын хоёр барын хэвлэлд Шадавдандар буюу Дандар аграмба ариутгал хийсэн нь эргэлзээгүй байна.

Зохиогч Дармаринчингийн тайлбарын Дашлхүнбо, Гүнбум хоёр барын хэвлэлийн алдаа мэдгийг ариутгахдаа Дигнагагийн Праманасамуччая, зохиогчийн өөрийн тайлбарт¹⁹ тулгуурлан, Гүнбум барыг гол болгон шүүсэн байна. Зохиогч энэ тухай өгүүлсэн нь: "de yang Sku' bum dpar dang Bkra-shis-lhun-po'i dpar gnyis po mdo rang nyid kyil rang 'grel Zha-ma Senge-gyal-mtsang dang Dad-pa'i-shes-rab gnyis kyil bskur dang bstur nas yig dag ma dag dpyad par de la **shog grangs smos pa ni Sku** 'bum dpar gyil dbang du byas so/4 «Тэрчүү Гүнбум, Дашлхүнбо хоёр барыг, Шамасэнгэжалцан, Дадбийшийрав хоёрын орчуулсан шалгадаг судар, өөрийн тайлбараар мэдгийг шинжлэн үсгийг ариутгаж, хуудасны тоог Гүнбум барын эрхэнд үйлдмөй» гэжээ.

Дандар аграмба уг ариутгалдаа Дармаринчингийн тайлбарын дотор буй үг, үсэг, өгүүлбэрийн болон утгын талаар илүүдсэн, орхигдсон, солигдсон нийт 204 алдааг олж зассан бөгөөд ингэхдээ тухайн алдаа байгаа хуудасны дугаар, ар, өвөр нүүр, мөрийг ялган зааж, тодорхой тэмдэглэн зассан байна. Жишээлбэл: Гүнбум барын судар 11-р хуудас, өвөр нүүр, дөрөв дэх мөрөнд (11. а. 4) gnyis pa ni (хоёр дугаарах нь) хэмээснийг gsum pa ni (гурав дугаарах нь гэж, 12-р хуудас, өвөр нүүр, дөрөв дэх мөрөнд (12. а. 4) nam 'grel nges byed kyil nam bshad du (тийн тайлбар магад үйлдэхийн тийн тайлбарт) гэсэн мэдгийг (nam 'grel nam nges kyil nam bshad du) (тийн тайлбар, тийн магадлалын тайлбарт) гэж засах хэрэгтэй гэсэн байна.

Энд Дармаринчин Дармакиртийн (VII зуун) шалгадаг ухааны салбарт бичсэн долоон²⁰ зохиолын хоёр тайлбараас ишлэл авсан байна. Гэтэл Дармакиртийн бүтээлийн дотор «Магад үйлдэх» нэртэй зохиол байхгүй тул Дандар аграмба «Тийн магадлал-nam nges» гэж засса, нь зөв бөгөөд энэ зохиол нь Дигнагагийн «Праманасамуччая» -гийн хоёр дахь тайлбар юм.

16. Хоёр бар гэдэг нь Дарма ринчингийн тайлбарын Дашлхүнбо, Гүнбумын хоёр хийдэд барлагдсан бар болно.

17. Хоёр цол гэдэг нь гавьж, аграмбын хоёр цол

18. Дандар аграмба нь ихэнхи зохиолынхоо төгсгөлд өөрийнхөө нэрийг цадав дандар гэж бичдэг бөгөөд олонд ч Чин вангийн Шадавдандар гэж алдаршжээ.

19. Төвд хэлэнд тухайн зохиогч өөрийнхөө бичсэн зохиолд өөрөө тайлбар бичихийг «ран-дэл-rang 'grel буюу өөрийн тайлбар» гэж нэрлэдэг

20. -Праманавартика (Pramanavarttikarika)

— Праманавиничая (Pramanaviniscaya)

— Ньяявиндунамапрака рана (Nyayabhinclū-nāma-prakarana)

— Хэтувиндупракарана: (Hetubindu-nama-prakarana)

— Самбандхапариксакракарана (Sambandhapariksi-prakarana).

— Ваданьянамапракарана (Vādanyāna-nāma-prakarana)

— Самтанатаррасдхипракарана (Samtanantarāsiddhi-nama-prakarana) зохиолоороо Дармакирти «Праманасамуччая»-г дэлгэр хураангуй тайлбарласан ба энэ нь Дэргэ Данжуурвин 183-р ботид 94—359-р талд бий.

Цааш нь зохиогч зарим нэгэн алдааг засахдаа Дашлхүнбогийн бар, Данжуурт байгаа тайлбар болон бусад номыг баримтлан тэдгээрээс ишлэл авч, тодорхой үндэслэл баталгаатай зассан байна.

Харамсалтай нь зохиогч тэдгээр ишлэл авсан ном, зохиогчийн нэр, хуудасны дугаарыг заагаагүй байна.

Жишээлбэл: Гүнбум барын 36-р хуудасны өвөр нүүрний 5 дахь мөрөнд (36.а.5) *mi gsal ba'i don dag 'dis rtags su dprog par gyed par byed pasrtaqaste*) гэснийг алдаа гэж үзээд Данжуурт байгаа тайлбарт²¹ (*mi gsal ba'i dan gnyis rtags su rtogs par byed pas bdags te*) гэж байгаа, Дашлхүнбогийн бард (*mi gsal ba don dag 'dis rtads su byed rtogs par byed pas rtogs te*)²² гэж байгааг тус тус ишлэл авч дээрэх мэдгийг зассан боловч уг ишлэл эдгээр номын хэд хэддүгээр хуудсанд байгааг тодорхой заагаагүй байна.

Дандар аграмбын хийсэн энэ ариутгалыг танилцуулахдаа (А) үсгээр Дигнагагийн тайлбарыг, (Б) үсгээр тайлбарын тайлбарыг, (В) үсгээр Дармаринчингийн тайлбарын Гүнбум, Халхын Их Хүрээний бар, (Г) үсгээр мөн тайлбарын Дашлхүнбогийн бар, нэмэх (+) тэмдгээр илүүдсэнийг хасах (—) тэмдгээр орхогдсоныг, үржүүлэх тэмдгээр (X) солигдсоныг, цэцгээр С) утгын алдааг тус тус тэмдэглэж, тэдгээрийн зассан байдлыг цөөн хэдэн жишээн дээр авч үзье.

(х) В барын хуудас 26-ын өвөр нүүрийн зургаа дахь мөрөнд *dbang po tha dad med kyang zhes gang brjod pa dbang po tha dad kyi las*) гэснийг мадаг гэж үзсэн бөгөөд (А) эхэд (*bang po thams cad kyi tha dad las du mar briod pa ni ma yin te*) гэж байгаа тул (*dbang po thams cad kyi tha dad las du mar bsgrub bar bya ...*) хэмээх засах хэрэгтэй гэж үзсэн байна.

(*) В барын (8. а. 2), (Г) барын хуудас 6-ын ар нүүрийн тав дахь мөрөнд (*sngar ksang nang du mthong ba'i mngon sum gyis tzan dan gyi me rtogs nas*) гэснийг мадаг гэж үзээд Праманавартикагаас (*skad cig so sor tha dad phyir*) гэдгээс (*dran min ma yin 'khrul phyir ro*) хүртэл ишлэл аваад²³, мөн энэ ишлэлийг тайлбарласан тайлбараас (*sngar byung ba de lta bu min par shang ste*) 'di ni ksang nang du mtsong ba'i tzan dan gyi me de phyis su khang pa'i phyi rol du du ba'i rtags las sngar gyi me de nyid 'di'o siyam du ngo shes pa thad ma phung sum par dogs pa bsus nas bkod pa yin pa'i phyir) гэж ишлэл авч дээрх алдааг (*sngar khang nang du mngon sum gnyis tzan dan gyi me rtogs-nas*) гэх буюу (*sngar khang nang me mthong ba'i mngon sum gyis tzan dan gyi me trogs nas*) хэмээн засах нь зүйтэй гэж үзсэн байна.

(+) В барын хуудас 5-ын ар нүүрийн дөрөв дэх мөрөнд (*le'u'i mtsan bshad bstan pa'o//dang po la gsum / rang lugs kyi mngon! sum sgrub pa dang/gzhan gyis btags pa'i mngon sun dgag pa/de la brten nas gdul bya rjes su 'dzin pa'i thabs bshad pa'o/ rigs pa'i sgor/mngon sum dang ni rjes su dpag ltar snang bcas pa bdag rig byed//sgrub pa dang ni sun 'byuni ngag/ ltar shang bcas pa gzhan rtogs byed//ces rtog ge'i tsig don brgyad don tsan gnyis su bsdus pa ltar bshad pa'i// хэмээсэн хэсэг нь илүүдсэн бөгөөд харин gnyis pa bshad pa nye bar dgod pa la/ rang gis gzhal bya'i gnas mtha' dag rtogs pa'i thabs bshad pa de la brten nas gdul bya rjes su 'dzin pa'i thabs bshad pa'ol dang po la gnyis/ гэж байх ёстой гэсэн байна.*

21. Дэргэ Данжуур, 189-р боть, 81-р (81. а. 4) тал

22. Дашлхүнбогийн бар, 35-р (35. б. 4) тал

23. Дэргэ Данжуур 183-р боть, "tsad ma rnam grel gyi tsig le'ur byas pa las mngon sum gyi lefu" 123-р тал

(—) Гбарын (35. а. 1), В барын хуудас 35-ын ар нүүрийн хоёр дахь мөрөнд /le'u'i mtsan bstan pa'o/ гэсний сүүлд /dang po la gnyis/ rjes dpag gi dbye ba dang/ rang don rjes dpag bye brag tu bshad pa'o/ dang po ni/ гэж байгаа нь орхигдсон байна.

(X) В барын (60.б.1), (Г) барын хуудас 59-ын өвөр нүүрний гурав дахь мөрөнд /gnyis pa de la brten nas gdul bya gzhan ries su 'dzin pa'i thabs bshad pa la gsum/ rgol ba'i rten can sgrub ngag yan lag dang bcas pa bshad pa dang/ gnyis ka'i rten can sgra rtog gi 'jug tsul gzhan sel ba bshad pa dan/ phyir rgol gyi rten can sun 'byin ltar snang ltag chod bshad pa'o/ dang po la gnyis/ sgrub ngag dang sgrub ngag ltar snang bshad pa dang/pde dang dpe ltar snang bshad pa o/dang pola gnyis/le'u'i gzhung bshad pa dang/ le'u'i mtsan bstan pa'o/ dang po la gnyis/ rang gi lugs bshad pa dang/ гэж байх нь хойно өмнө орон солигдсон байна.

(X) В барын хуудас 32-ын ар нүүрийн хоёр дахь мөрөнд /gnyis pa la gnyis/ гэж буйг (Г) барын (32. а. 3)-д /gsun pa la gsum/ гэж байгаагаар, В барын 60-ын ар нүүрэнд 5 дахь мөрөнд gis tsad mas mthong ba'i... гэснээс үргэлжлээд /tsul gsum gyi don Thag ma dang bral bar rab tu/ гэснийг (Г) барын (59. а. 1)-д /tsul bsum gyi don ltag chad dang bral bar/ гэж байгаа мэт олон алдааг (Г) барыг үндэслэн зассан байна.

Бас зарим алдаа мадгийг ариутгахдаа Дигнагагийн өөрийн бичсэн тайлбар болон бусад тайлбаруудыг үндэс болгон зассан ч байна.

Энэ бүхэн бол зохиогч уг ариутгалыг хийхдээ, нэг талаар эх сурвалж бичигт тулгуурлаж сайн нягталсан, нөгөө талаар өгүүлэн буй зүйлийнхээ утгыг өөрөө сайн мэддэгийг харуулж байна.

Дармаринчингийн «Праманасамуччая»-гийн тайлбар доторхи үг, үсэг болон утгын талаар гарсан олон алдаа мадгийг Дандар аграмба зассаныг цөөн хэдэн жишээ дээр үзүүлэв.

Дандар аграмбын «Шалгадаг судрын Дармаринчингийн тайлбар, Даш Л Хүнбо, Гүнбум хоёр барын үсгийн гэм сэжгийг таслагч зэндмэний Гэдага» нь «Праманасамуччая»-г судлах, түүний төвд тайлбарын үнэн зөв эхийг олж тогтооход эрдэм шинжилгээний үлэмжийн ач холбогдолтой нь илэрхий.

Иймд цааш нь уг ариутгалыг товч тайлбартай, эхийн хамт хэвлэж судалгааны хүрээнд оруулбал зүйтэй бол уу гэсэн саналыг дэвшүүлж байна.